

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 10-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, “Сэндли ББСБ” ХК-ийн дүрмийн 8 дүгээр зүйлийн 8.6.13, 8.6.14 дэх заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2025 оны 04 сарын 30-ны өдрийн 14 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Арт хаус центр, 6 давхар, хурлын танхимд болон цахим хосолсон хэлбэрээр зарлан хуралдуулсугай.
2. Хурал зарлах тухай мэдэгдлийг 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид, 2026 оны 03 дугаар сарын 30-ний өдрийн дотор Хувьцаа эзэмшигчид үйлчилж байгаа Үнэт цаасны компаниудад тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2026 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөр тогтоосугай.
5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг хуулийн хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д үүрэг болгосугай.
6. Хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Наранбат-г томилсугай.
7. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:
 - 7.1. Хурал зохион байгуулах комиссын дарга: Д.Баярбат
 - 7.2. Хурал зохион байгуулах комиссын гишүүд: Х.Ичинхорлоо, Т.Энхбаяр
8. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
 - 8.1 Хурлын тооллогын комиссын дарга: А.Итгэлт
 - 8.2 Хурлын тооллогын комиссын гишүүд: И.Оюунбат, П.Болорчулуун
9. Хурлаар танилцуулах болон хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг Хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарыг Гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг Дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн саналыг саналын хуудсаар хүлээн авах эцсийн хугацааг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 16:00 цаг байхаар тогтоосугай.

11. Хувьцаа эзэмшигчдийг Хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс /Д.Баярбат/-д даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалтыг цахим хэлбэрээр явуулах, үүнд санал хураалтад оролцогчийг системд бүртгэх, түүний саналыг авах, авсан саналын дүнг өөрчлөх боломжгүйгээр гүйцэтгэх, хуралд оролцогч бүрийн өгсөн саналыг хэвлэж, үнэн зөв болохыг баталгаажуулж, компанид хүлээлгэж өгөх үүрэг хүлээх зохих туршлага бүхий мэдээллийн технологийн компанитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАЙБАТ



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 он 03 дугаар сарын
20-ны өдрийн 04 тоот тогтоолын Хавсралт №01

**“СЭНДЛИ ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР
ТАНИЛЦУУЛАХ БОЛОН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг танилцуулна. Үүнд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг танилцуулах;

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлүүлнэ. Үүнд:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төсөв батлах тухай;

-----oOo-----

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 он 03 дугаар сарын
20-ны өдрийн 04 тоот тогтоолын Хавсралт №02

**“СЭНДЛИ ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН
ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн/оноосон нэр/ овог.....нэр

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

регистрийн дугаар

Санал өгөх хувьцааны тоо:

Бүртгэсэн / Үнэт цаасны компани /:

Брокерийн овог нэр

“Сэндли ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хосолсон (цахим болон танхим) хэлбэрээр Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Арт хаус центр, 6-н давхар, хурлын танхимд 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14 цагт зохион байгуулахаар шийдвэрлэв.

№	Хэлэлцэх асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах			
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төсөв батлах тухай			

(Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт + тэмдгийг бичнэ үү.)

Хувьцаа эзэмшигч Гарын үсэг

Брокер Гарын үсэг

/тэмдэг/

2026 оны ... сар ... өдөр

САНАЛЫН ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ:

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч үнэт цаасны компани (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад саналын хуудсаар саналаа өгч болно.
 2. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байна.
 3. Засварласан болон балласан, залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.
 4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг 70157700 утсаар лавлаж болно.
- Саналын хуудас хүчингүйд тооцсон бол түүний үндэслэл

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 он 03 дугаар сарын
20-ны өдрийн .../... тоот тогтоолын Хавсралт №03



**“СЭНДЛИ ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР**

Хурлын хэлбэр: Хосолсон (Танхим болон цахим)

Хурал болох өдөр, цаг: 2026 оны 4-р сарын 30-ний өдөр 14:00

Компанийн оноосон нэр: “Сэндли ББСБ” ХК

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төсөв батлах тухай

Бүртгэлийн өдөр: 2026 оны 04-р сарын 14-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийн төсөл.
2. Компанийн 2026 оны үйл ажиллагаа болон санхүүгийн аудитлагдсан тайлан.

Хувьцаа эзэмшигчид өөрийн харилцагч үнэт цаасны компани, хурал зохион байгуулах комисстой холбогдож, эсхүл компаний цахим хуудсаар дамжуулан хурлаар хэлэлцэх асуудал болон гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцаж болно.

Хурал зохион байгуулах комиссын гишүүдтэй Даваа-Баасан гаргуудад 09:00-17:00 цагийн хооронд дор дурдсан хаяг, утсаар холбогдох боломжтой.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Арт хаус центр, 6 давхар, хурлын танхим

Харилцах утас: 7533-0077, 88269595

Цахим шуудан: info@sendly.mn

Хурал зохион байгуулах комисс

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 он 03 дугаар сарын
20-ны өдрийн 04 тоот тогтоолын Хавсралт №04

**“СЭНДЛИ ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД
БЭЛТГЭХ ЯВЦАД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ
БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийн төсөл;
2. Компанийн 2026 оны үйл ажиллагаа болон санхүүгийн аудитлагдсан тайлан.